

БАТЛАВ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГА Ц.ШАРАВЖАМЦ



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СПОРТЫН VII НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр
Улаанбаатар хот

АГУУЛГА:

- 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**
- 2. НААДМЫН ХӨТӨЛБӨР**
- 3. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**
- 4. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ**
- 5. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХУГАЦАА**
- 6. ТАМИРЧДЫН ЭРХИЙН БАТАЛГААЖИЛТ**
- 7. ЦАХИМ БҮРТГЭЛ**
- 8. САНХҮҮЖИЛТ**
- 9. ДҮГНЭХ**
- 10. СПОРТЫН ТӨРӨЛ**
- 11. ГАДААДАД ЗОХИОГДОХ ТЭМЦЭЭН**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5; 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2 дугаар заалтын 2.1 дэх хэсгийг үндэслэн Монголын үндэсний спортын наадмыг зохион байгуулахад энэхүү зааврыг баримтална.

1.2. Монголын үндэсний спортын VII наадмын /цаашид наадам гэх/ зорилго нь үндэсний уламжлалт спортын төрлүүдийг хөгжүүлэх, хамгаалах, уламжлалт тоглоом наадгайн зан үйл, үндэстний ёс заншил, соёл, соёлын өвийг өсвөр залуу үеийнхэнд өвлүүлэх, сурталчлан таниулахад оршино.

1.3. Үндэсний спортын наадамд дараах зарчмыг баримтална.

- **ШИЛДЭГ:** Үндэсний спортын наадмын оролцогчид нь уламжлалт үндэсний спортын төрлөөр төв, орон нутгаас шалгарсан тамирчид байна.
- **ХҮРТЭЭМЖТЭЙ:** Улсын хэмжээнд үндэсний спортоор хичээллэгсдийн бүх нийтийн оролцоог хангаж, оролцогчдын эрхийг эрхэмлэн, иргэн бүр оролцох боломжийг бүрдүүлнэ.
- **ШУДАРГА:** Уламжлалт соёл, зан үйл, ил тод шүүлт, цэвэр шударга өрсөлдөөн, тамирчны ёс зүйг эрхэмлэнэ.
- **ТОГТВОРТОЙ:** Зан үйл, соёл, спортын бүтээгдэхүүнийг бий болгох, үндэсний соёлын биет бус өвийг хөгжүүлэх, өвлөн уламжлуулна.

1.4. Монголын үндэсний спортын VII наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлүүд, тэмцээнд оролцогч байгууллага, тэмцээний удирдлага зохион байгуулалт, санхүүжилт, тайлан, дүгнэх арга аргачлалыг багтаасан болно. Үүнд:

Шигшээ тэмцээний медалийн тоо, спортын төрлөөр:

- Тэмцээн
- Оролцогчдын тоо
- Шигшээ тэмцээнд оролцох эрхийн тоо
- Байгууллагын оролцогчдын нийт тоо /дээд хязгаар/
- Наадмын шигшээ тэмцээний сонгон шалгаруулалт
- Хугацаа, үе шат
- Эрхийн баталгаажилт, эрх шилжүүлэх
- Спортын холбоодын ерөнхий мэдээлэл

ХОЁР. НААДМЫН ХӨТӨЛБӨР

2.1. Монгол Улсын хэмжээнд олон нийтийн дунд түгээмэл дэлгэрсэн үндэсний спортын зуны 9, өвлийн 2, шинэ тутамд хөгжиж буй спортын 5 төрлөөр үзүүлэх тоглолтыг зохион байгуулна.

2.2 Наадмын хөтөлбөрийн хүрээнд Гадаадад амьдарч буй Монгол иргэдийн дунд спортын зарим төрлийн тэмцээнийг наадмын Зохион байгуулах хороо, Гадаад харилцааны яам, тухайн улс дахь Элчин сайдын яам, Консулын газар, Монголчуудын спортын төрийн бус байгууллагууд хамтран Монгол иргэдийн оролцоог хамгийн ихээр

хангах бололцоотой улс, хотыг сонгож, баталсан заавар, удирдамжийн дагуу зохион байгуулна.

Спортын төрөл	Медалийн тоо (багц)				Тамирчдын тоо		
	Эр	Эм	Баг	Бүгд	Эр	Эм	Бүгд
Үндэсний бөх	4	-	1	5	120	-	120
Үндэсний сурын харваа	2	2	1	5	300	120	420
Хурдан морины уралдаан	3	-	-	3	90	-	90
Шагайн харваа	-	-	1	1	240	-	240
Ширээний шагай	2	2	1	5	60	60	120
Уран уургач, бугуйлч, эмнэг булгиулагч	3	-	-	3	90	-	90
Буриад сурын харваа	1	1	1	3	300	30	330
Урианхай сурын харваа	1	-	1	2	390	-	390
Уламжлалт сурын харваа	1	1	1	3	150	90	240
Мөсний шагайн харваа	1	-	2	3	180	-	180
Мөсний сурын харваа	1	-	1	2	300	-	300
Морьт сурын харваа	4	4	-	8	30	30	60
Морин дээрх барилдаан	6	-	-	6	180	-	180
Морин өртөө уралдаан	1	-	-	1	30	30	60
Жороо морины уралдаан	1	-	-	1	30	30	60
Тэмээн уралдаан	2	-	-	2	16	16	32
нийт	33	10	10	53	2506	406	2912
Гадаад оронд оршин суугаа иргэдийн дунд зохион байгуулах тэмцээн							
Үндэсний бөх	3	-	-	3			75
Үндэсний сурын харваа	3	3	-	6			130
Шагайн харваа	-	-	3	3			520
нийт	6	3	3	12			725
Бүгд	39	13	13	65	-	-	3737

ГУРАВ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1.Оролцогч байгууллага:

- 3.1.1 Наадмын оролцогч нь 21 аймаг, 9 дүүрэг байна.
- 3.1.2 Спортын клуб, хүчний спортын байгууллага нь засаг захиргааны нэгж дэх байршлын дагуу тухайн аймаг, дүүрэгт харьяалагдана.
- 3.1.3 Зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах байгууллагын спорт хороо, спортын клуб нь баг, тамирчдаа тухайн засаг захиргааны нэгжийн анхан шатны тэмцээнд оролцуулсан байна.
- 3.1.4 Наадамд оролцогчдийн үндсэн байгууллага нь эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна.

3.2. Тамирчинд тавигдах шаардлага:

- 3.2.1 Монгол Улсын иргэн байна.
- 3.2.2 Тухайн спортын холбооны дүрэмд заасан ангиллаар оролцоно.
- 3.2.3 Тамирчин анхан шатны тэмцээнд бүртгэгдсэн цахим бүртгэлээр шигшээ тэмцээнд оролцоно.
- 3.2.4 Оролцогчийн гэрээ байгуулсан байна. /цахим гэрээ/
- 3.2.5 Наадмын оролцогч нь зуны спортын 2 төрлийг сонгон оролцоно.

ДӨРӨВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

4.1. Наадмын оролцогч тамирчдыг дараах үе шатаар сонгон шалгаруулна.

1. Аймаг, дүүрэг
2. Шигшээ тэмцээн

4.2.Тамирчин өөрийн сонголтоор хичээллэж буй клуб, харьяалагдах байгууллага, засаг захиргааны нэгжийн аль нэг анхан шатны тэмцээнд оролцох сонголтоо хийж болно.

ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХУГАЦАА

5.1 Наадмын зуны төрлийн анхан шатны тэмцээнийг аймаг, дүүргийн Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын газар /хороо/-д спортын салбар холбоод хамтран 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулна.

5.2 Наадмын зуны төрлүүдийн шигшээ тэмцээн болон үзүүлэх тоглолтын төрлүүдийг Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын улсын хороо, спортын холбоод хамтран 2022 оны 08 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Сонгино-хайрхан дүүргийн “Хүй долоон худаг”-т зохион байгуулна.

5.3 Наадмын өвлийн спортын үндсэн төрөл мөсний шагай, мөсний сурын тэмцээнийг Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын улсын хороо, спортын холбоод хамтран 2022 оны 02 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Улаанбаатар хот “Скай ресорт”-д зохион байгуулна.

5.4 Өвлийн спортын үзүүлэх тоглолт тэмээн уралдааныг Зохион байгуулах хороо, Аймгийн Биеийн тамир, спортын хороо, тэмээн уралдааны холбоод хамтран

03 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан суманд зохион байгуулна.

5.5. Гадаадад амьдарч буй Монгол иргэдийн дунд зохиогдох спортын зарим төрлийн үзүүлэх тоглолтын тэмцээний товыг наадмын шигшээ тэмцээний дурдсан хугацаанд багтаан зохион байгуулна.

ЗУРГАА. ТАМИРЧДЫН ЭРХИЙН БАТАЛГААЖИЛТ

6.1. Зохион байгуулах хороо шилдэг, хүмүүнлэг, хүртээмжтэй, шударга, тогтвортой үзэл баримтлалыг хангаж, спортын холбооны дүрмийн дагуу анхан шатны тэмцээнээс шалгарсан баг, тамирчдад наадмын шигшээ тэмцээнд оролцох эрхийг олгож, баталгаажуулна.

6.2. Зохион байгуулах хороо шигшээ тэмцээний эрхийн баталгаажилтыг спортын төрөл тус бүрийн тэмцээн эхлэх хугацаанаас 10 хоногийн өмнө баталгаажуулна.

6.3. Эрх нь баталгаажсан баг, тамирчин хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шигшээ тэмцээнд оролцох боломжгүй тохиолдолд эрхийн эцсийн баталгаажилт хийгдэхээс 5 хоногийн өмнө Зохион байгуулах хороонд мэдэгдэнэ.

6.4. Зохион байгуулах хорооноос дараагийн эрэмбэлэгдсэн баг, тамирчинд 5 хоногийн дотор эрхийг шилжүүлэн баталгаажуулна.

ДОЛОО. ЦАХИМ БҮРТГЭЛ

7.1. Тоон мэдүүлэг

Анхан шатны зуны спортын төрлийн тэмцээний баг, тамирчдын тоон мэдүүлгийг цахимаар авна. Тоон мэдүүлгийн бүртгэлийн систем 2022 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд батлагдсан загварын дагуу файлаар авна.

Өвлийн спортын төрлийн тэмцээний баг, тамирчдын тоон мэдүүлгийг цахимаар авна. Тоон мэдүүлгийн бүртгэлийн систем 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрийн хооронд батлагдсан загварын дагуу файлаар авна.

Тоон мэдүүлгийг games@sport.gov.mn цахим шуудангаар ирүүлнэ.

7.2. Нэрэн мэдүүлэг

- Өвлийн төрлийн тэмцээний баг, тамирчдын нэрэн мэдүүлгийг цахимаар авна. Өвлийн спортын нэрэн мэдүүлгийн бүртгэлийн систем 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр нээгдэж, 02 дугаар сарын 15-ны өдрийн 22:00 цагт хаагдана.

- Анхан шатны зуны төрлийн тэмцээний тамирчдын нэрэн мэдүүлгийг цахимаар авна. Зуны спортын нэрэн мэдүүлгийн бүртгэлийн систем 2022 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн 06:00 цагаас нээгдэж 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 22:00 цагт хаагдана.

7.3. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод цахим бүртгэлд дараах оролцогчдыг бүртгүүлнэ. Үүнд:

- Тамирчин
- Дасгалжуулагч
- Багийн ахлагч
- Эмч

7.4. Зохион байгуулагчийн цахим бүртгэлд дараах ажилтнуудыг бүртгэнэ. Үүнд:

- Ерөнхий шүүгч
- Шүүгч
- Тэмцээний нарийн бичиг
- Зохион байгуулагч
- Сайн дурын ажилтан
- Холбооны ерөнхийлөгч
- Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга
- Албаны ажилтан
- Хүндэт зочин
- Хэвлэл, мэдээллийн ажилтан
- Бусад

7.5. Наадмын Зохион байгуулах хорооноос баталсан цахим бүртгэлийн зааварчилгааг оролцогч байгууллагуудад 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө хүргүүлж, тухай бүрд сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

7.6. Зохион байгуулах хорооны цахим бүртгэлийн ажлын хэсэг цахим бүртгэлийн бүхий л үйл ажиллагааг хариуцаж, хяналт тавьж ажиллана.

7.7. Цахим бүртгэлтэй холбоотой мэдээллийг www.sport.gov.mn цахим хуудсанд байршуулна.

НАЙМ. САНХҮҮЖИЛТ

8.1. Наадмын спортын төрлүүдийн анхан шатны тэмцээний зохион байгуулалттай холбоотой дараах зардлыг тухайн аймаг, дүүргийн Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын газар, хороод хариуцна. Үүнд:

- Тэмцээний заал, талбай, узелийн хөлс;
- Байгууллага, баг тамирчид, дасгалжуулагчдад олгох өргөмжлөлийн зардал;
- Тэмцээний шүүгчийн ажлын хөлс;
- Эмнэлгийн яаралтай болон анхны тусламж үйлчилгээний зардал;
- Тэмцээн зохион байгуулахад шаардлагатай спортын хэрэглэл материалын зардал;
- Мэдээлэл, сурталчилгааны хөлс
- Тээврийн үйлчилгээний зардал
- Тэмцээний нээлт, хаалтын арга хэмжээний зардал

8.2. Аймаг, дүүргийн Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын газар, хороод шигшээ тэмцээнд баг тамирчдаа оролцуулахтай холбоотой дараах зардлыг хариуцна. Үүнд:

- Тэмцээнд оролцох баг тамирчдын бэлтгэл цугларалт, байр, хоол, унаа, бэлтгэлийн хувцас, хэрэгслийн зардал;
- Тээврийн үйлчилгээний зардал;
- Эмнэлгийн яаралтай болон анхны тусламж үйлчилгээний зардал;

8.3. Наадмын шигшээ тэмцээний зохион байгуулалтад шаардагдах зардлыг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, Зохион байгуулах хороо хариуцна. Үүнд:

- 8.3.1 Тэмцээний заал, талбайн түрээс, узелийн хөлс;
- 8.3.2 Байгууллага, баг тамирчид, дасгалжуулагчдад олгох мандат, цом, медаль, өргөмжлөлийн зардал;
- 8.3.3 Тэмцээний шүүгчийн ажлын хөлс;
- 8.3.4 Эмнэлгийн яаралтай, анхны тусламж үйлчилгээний зардал;
- 8.3.5 Зохион байгуулах хорооны үйл ажиллагааны зардал;
- 8.3.6 Мэдээлэл, сурталчилгааны зардал
- 8.3.7 Тээврийн үйлчилгээ, шатахууны зардал
- 8.3.8 Нийтлэг үйлчилгээний зардал
- 8.3.9 Халдвар хамгаалалт, ариутгалын зардал
- 8.3.10 Заал талбайн тохижилт
- 8.3.11. Хэвлэл, эх бэлтгэлийн зардал
- 8.3.12 Сайн дурын ажилтны зардал
- 8.3.13 Нээлт, хаалтын арга хэмжээний зардал

8.5. Шигшээ тэмцээнд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчдад Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 173 тогтоолоор батлагдсан “Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ын дагуу мөнгөн шагналаар шагнана.

8.6. Шигшээ тэмцээнд амжилттай оролцсон 6 аймаг, 3 дүүргийн Зохион байгуулах хороонд цом, өргөмжлөлөөр шагнана.

8.7. Шигшээ тэмцээнийг амжилттай зохион байгуулсан шилдэг 5 спортын холбоонд цом, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр шагнана.

8.8. Шигшээ тэмцээнд баг, тамирчдаа амжилттай бэлтгэн оролцуулсан Зэвсэгт хүчин, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллагын 3 спорт хороо, 3 спортын клубт цом, өргөмжлөлөөр шагнана.

8.9. Гадаад оронд оршин суугаа Монгол иргэдийн дунд зохион байгуулсан үндэсний спортын тэмцээний төрөлд тус бүр шалгарсан баг, тамирчдад наадмын медаль, өргөмжлөлийг Зохион байгуулах хорооноос олгоно.

ЕС. ДҮГНЭХ

9.1. Наадамд оролцогч байгууллагуудыг дүгнэхдээ спортын наадмын дүгнэх аргачлалын дагуу оролцогч байгууллагуудын медалийн чанараар дүгнэж байр эзлүүлнэ.

АРАВ. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СПОРТЫН ТӨРЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ШИГШЭЭ ТЭМЦЭЭН ЗОХИОГДОХ ХУГАЦАА, БАЙРШИЛ

№	Спортын төрөл	Оролцогчдын тоо	Хугацаа	Байршил
Зуны спортын төрөл				
1.	Үндэсний бөх	Улс, аймаг, сумын цолтой болон цолгүй Нийт-4 бөх	VIII/10-15	“Хүй долоон худаг” Улаанбаатар хот
2.	Үндэсний сурын харваа	Багийн харваа-15 хүн	VIII/10-15	“Хүй долоон худаг” Улаанбаатар хот

		Цуваа харваа-1 эрэгтэй, 1 эмэгтэй, Зэв нүүлгэх-1 эрэгтэй, 1 эмэгтэй		
3.	Хурдан морины уралдаан	Азарга, их нас, сонгомол морины уралдаан	VII/20-21	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
4.	Шагайн харваа	Багийн харваа -8 хүн	VIII/10-15	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
5.	Ширээний шагай	Ганцаарчилсан:эрэгтэй-1, эмэгтэй-1, охид-1, хөвгүүд-1 /16 хүртэлх насны/, Багийн тоглолт: 4 хүн	VIII/10-15	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
6.	Уран уургач, бугуйлч,эмнэг булгиулагч	Уургач-1, бугуйлч-1, эмнэг булгиулагч-1,	VIII/10-15	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
7.	Буриад сурын харваа	Багийн харваа-10 Цуваа харваа-1 эрэгтэй, 1 эмэгтэй	VIII/12-14	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
8.	Урианхай сурын харваа	Багийн харваа-12 Цуваа харваа-1 эрэгтэй,	VIII/12-14	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
9.	Уламжлалт сурын харваа	Багийн харваа: эрэгтэй-5, эмэгтэй-3 нийт-8 хүн Цуваа харваа-1 эрэгтэй, 1 эмэгтэй,	VIII/11-15	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
Өвлийн спортын төрөл				
10.	Мөсний шагайн харваа	Талын харваа-1хүн Цуваа харваа-2 хүн Багийн харваа-6 хүн	II/18-20	"Скай ресорт" Улаанбаатар хот
11.	Мөсний сурын харваа	Цуваа харваа-2 хүн Багийн харваа-10 хүн	II/18-20	"Скай ресорт" Улаанбаатар хот
Үзүүлэх тоглолтын төрөл				
1.	Морьт сурын харваа	Угтаж, өнгөрч харвах төрөл Бөмбөг намнаа төрөл Үндсэн 5 байны төрөл Дэлгэмэл 3 байны төрөл тус бүрд 1 эрэгтэй, 1 эмэгтэй,	VIII/10-15	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
2.	Морин дээрх барилдаан	60кг, 70кг, 80кг, 90кг, +90кг, үнэмлэхүй жин тус бүрд- 1 хүн	VIII/10-15	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
3.	Морин өртөө уралдаан	Аймаг, дүүргээс тус бүр 1 элч	VIII/05-14	Өвөрхангай,Архангай, Булган, Төв аймгийн нутгаар 1000км
4.	Жороо морины уралдаан	Аймаг, дүүргээс тус бүрээс жороо морьтой 1 хүн	VIII/10-15	"Хүй долоон худаг" Улаанбаатар хот
5.	Тэмээн уралдаан	2 насны /тором, ат/ ангилал	III/05-06	Өвөрхангай, Баруунбаян- Улаан сум

НААДМЫН ХӨТӨЛБӨР, СПОРТЫН ТӨРЛҮҮД:

10.1. ҮНДЭСНИЙ БӨХ:

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
4	-	1	5
Улс, аймаг, сумын цолтой, цолгүй -4 бөх			

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
-	-	120	120

Тэмцээний хугацаа: 2022.08.10-15
Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01

Спортын холбоо: Монголын үндэсний бөхийн холбоо
Хаяг: БЗД-н 13 хороолол, Монгол бөхийн өргөө
Холбоо барих утас: 96969687

10.2. ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВАА

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
2	2	1	5
Цуваа харваа, зэв нүүлгэлт	Цуваа харваа, зэв нүүлгэлт	15 харваачтай	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
300	120	420	390

Тайлбар: Багийн харваа-15 хүн, цуваа харваа-1 эрэгтэй, 1 эмэгтэй, зэв нүүлгэх-1 эрэгтэй, 1 эмэгтэй
Тэмцээний хугацаа: 2022.08.10-15
Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01

Спортын холбоо: Монголын үндэсний харваачдын холбоо
Хаяг: ХУД-н 4-р хороо, МҮОХ
Холбоо барих утас: 94119677, 89105448

10.3. ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
3	-	3
Азарга, их нас, сонгомол морины уралдаан		-

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
90	-	90

Тэмцээний хугацаа: 2022.07.20-21
Эрх баталгаажих хугацаа: 2022.07.10
Холбоо барих утас: 91040004

10.4. ШАГАЙН ХАРВАА

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Багийн харваа	Бүгд
-	1	1
	8 харваач	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
240	-	240

Тайлбар: Шигшээ тэмцээнд багийн харваа -8 хүнтэй байна.
Тэмцээний хугацаа: 2022.08.10-15
Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01
Спортын холбоо: Монголын Шагайн харвааны холбоо

Хаяг: ХУД Чингисийн өргөн чөлөө, МҮОХ-ны байр 108 тоот,
Холбоо барих утас: 99020920

10.5. ШИРЭЭНИЙ ШАГАЙ

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Холимог баг	Бүгд
2	2	4	5
эрэгтэй-1, хөвгүүд-1	эмэгтэй-1, охид-1	Холимог	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
60	60	120

Тайлбар:эрэгтэй-1, эмэгтэй-1, охид-1, хөвгүүд-1 /16 хүртэлх насны/,
багийн тоглолт: 4 хүн байна.

Тэмцээний хугацаа: 2022.08.10-15
Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01
Холбоо барих утас: 99207188, 80080408

10.6. УРАН УУРГАЧ, БУГУЙЛЧ, ЭМНЭГ БУЛГИУЛАГЧ

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Бүгд
3	3
Уургач-1, бугуйлч-1, эмнэг булгиулагч-1,	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
90	-	90

Тэмцээний хугацаа: 2022.08.10-15
Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01
Холбоо барих утас: 99115501

10.7. БУРИАД СУРЫН ХАРВАА

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
1	1	1	3
Цуваа харваа-1 эрэгтэй, 1 эмэгтэй		Багийн харваа-10	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг
300	30	330

Тэмцээний хугацаа: 2022.08.12-14
Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01
Хаяг: БЗД-ийн 10-р хороо, 2А "Билэг" ХХК-ийн байр
Холбоо барих утас: 99114515, 98020809

10.8. УРИАНХАЙ СУРЫН ХАРВАА

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Багийн харваа	Бүгд
1	1	2
Цуваа харваа-1 эрэгтэй, 1 эмэгтэй	Багийн харваа-12	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
390	-	390

Тэмцээний хугацаа: 2022.08.12-14

Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01

Холбоо барих утас: 88090667, 99803002

10.9. УЛАМЖЛАЛТ СУРЫН ХАРВАА**Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
1	1	1	3
Цуваа харваа-1 эрэгтэй, 1 эмэгтэй,		эрэгтэй-5, эмэгтэй-3 нийт-8	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
150	90	-	240

Тайлбар: Багийн харваа: эрэгтэй-5 эмэгтэй-3 нийт-8 хүн, цуваа харваа-1 эрэгтэй, 1 эмэгтэй,

Тэмцээний хугацаа: 2022.08.11-15

Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01

Спортын холбоо: Монголын Уламжлалт харваачдын холбоо

Холбоо барих утас: 99110036, 99051740

10.10. МӨСНИЙ ШАГАЙН ХАРВАА**Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Баг	Бүгд
1	2	3
Талын харваа	цуваа харваа-2 хүн ,багийн харваа-6 хүн	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
180	-	-	180

Тэмцээний хугацаа: 2022.02.18-20

Эрх баталгаажих хугацаа: 2022.02.08

Спортын холбоо: Монголын Үндэсний мөсний шагайн холбоо

Хаяг: БЗД-ийн 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 207-р байр96 тоот

Холбоо барих утас: 91069595

10.11. МӨСНИЙ СУРЫН ХАРВАА**Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Баг	Бүгд
1	1	2
Цуваа харваа	багийн харваа-10 хүн	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
300	-	-	300

Тайлбар: Цуваа харваа-1 хүн, багийн харваа-10 хүн байна.

Тэмцээний хугацаа: 2022.02.18-20

Эрх баталгаажих хугацаа: 2022.02.08
Спортын холбоо: Монголын Мөсөн сурын холбоо
Холбоо барих утас: 90090066

10.12. МОРЬТ СУРЫН ХАРВАА

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
1	1	-	2
Угтаж өнгөрч харвах, бөмбөг намнаа, үндсэн 5 бай, дэлгэмэл 3 байны төрөл		-	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
30	30	-	60

Тэмцээний хугацаа: 2022.08.10-15
Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01
Спортын холбоо: Монголын Морьт харваачдын холбоо
Хаяг: ХУД-ийн Өлзийт хороолол
Холбоо барих утас: 91928808

10.13. МОРИН ДЭЭРХ БАРИЛДААН

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Баг	Бүгд
6	-	6
60кг, 70кг, 80кг, 90кг, +90кг, үнэмлэхүй жин		

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
180	-	-	180

Тайлбар: тус бүрд-1 хүн
Тэмцээний хугацаа: 2022.08.10-15
Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01
Спортын холбоо: Монголын Көкпарын холбоо
Холбоо барих утас: 99429448

10.14. ЖОРОО МОРИНЫ УРАЛДААН

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Бүгд
1	1
Аймаг, дүүргээс тус бүр жороо морьтон	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
30	-	-	30

Тэмцээний хугацаа: 2022.08.10-15
Эрх баталгаажих хугацаа: 2022.08.01
Спортын холбоо: Монголын Үндэсний жороо морины спортын холбоо
Холбоо барих утас: 88849494

10.15. МОРИН ӨРТӨӨ УРАЛДААН**Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
1	1	-	2
Аймаг, дүүргээс тус бүр 1 элч		-	

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
30	30	-	60

Тэмцээний хугацаа: 2022.08.05-14

Эрх баталгаажих хугацаа: 2022.07.25

Спортын холбоо:

Арвагар хээрийн холбоо

Холбоо барих утас: 99052538

10.16. ХУРДАН ТЭМЭЭНИЙ УРАЛДААН**Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
2	-	-	2
тором, ат 2 насны ангилал			

Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
16	16	-	32

Тэмцээний хугацаа: 2022.03.05-06

Эрх баталгаажих хугацаа: 2022.02.25

Спортын холбоо: Өвөрхангай аймгийн Баруунбаян улаан сумын ЗДТГ,
Аймгийн тэмээчдийн холбоо

Хаяг: Өвөрхангай аймаг, Баруунбаян улаан сум

Холбоо барих утас: 99052538

10.17. ГАДААД УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ТЭМЦЭЭН**Медалийн тоо**

Эрэгтэй	Бүгд
Үндэсний бөх: 4 медаль х 3 улс	12 медаль
Үндэсний сур: эрэгтэй, эмэгтэй х 3 улс	18 медаль
Шагайн харваа баг-8 хүн х 3 улс	72 медаль
Нийт	102 медаль

Хамрагдах тамирчдын тоо боломжит

Америк тив	160 хүн
Европ тив	240 хүн
Ази тив	120 хүн
Бүгд	520 хүн

АРВАН НЭГ. ГАДААД ОРНУУДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ ИРГЭДИЙН СПОРТЫН ТЭМЦЭЭН

Үндэсний спортын наадмын хүрээнд үндэсний бөх, үндэсний сурын харваа, шагайн харвааны спортын төрлүүдээр тухайн спортын холбооны дүрмийн дагуу тэмцээнийг зохион байгуулна.

Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайдын яам, консулын газар, тус улсад үйл ажиллагаа явуулдаг спортын төрийн бус байгууллагууд хамтран тэмцээний заавар, удирдамжийг батлан зохион явуулна.

Тэмцээний зохион байгуулалтад Элчин сайдын яам, Консулын газраас дэмжлэг үзүүлнэ.

Тэмцээний заавар, удирдамжид зохион байгуулах хот, заал, талбайн байршил, хугацаа, багийн бүрдүүлэлт, зохицуулалт, төсөв, санхүүжилт бусад холбогдох мэдээллийг тодорхой тусгаж ажиллана.

Тэмцээнд оролцогчид нь хот, муж, улсаа төлөөлсөн хэлбэрээр оролцож болно.

Тэмцээнийг зохион байгуулагч комисс, спортын төрийн бус байгууллагаас техникийн зөвлөгөөнийг зохион байгуулна.

Наадмын Зохион байгуулах хорооноос тэмцээн тус бүрд шалгарсан баг, тамирчдыг Монголын Үндэсний спортын наадмын медаль, өргөмжлөлөөр шагнах бөгөөд тэмцээнийг зохион байгуулагч комиссоор дамжуулан олгоно.

Тэмцээнд оролцогчид байр, хоол, унааны зардлаа өөрсдөө бүрэн хариуцна.

АРВАН ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Наадам	Үндэсний спортын VII наадам
Салбар зохион байгуулах хороо	Засаг даргын захирамжаар байгуулагдсан аймаг, дүүргийн Зохион байгуулах хороо
Наадмын зохион байгуулах хороо	Биеийн тамир, спортын улсын хорооны даргын тушаалаар байгуулагдсан Зохион байгуулах хороо
Тамирчин	Наадамд оролцох этгээд /сонирхогч, уламжлалт үндэсний спортын төрлүүдээр хичээллэгчид/
Дасгалжуулагч	Тэмцээнд баг, тамирчдыг оролцуулах үйл ажиллагааг удирдаж байгаа этгээд
Ерөнхий шүүгч	Улсын цолтой болон спортын холбооны эрх бүхий этгээд
Шүүгч	Улсын цол, зэрэгтэй тухайн спортын холбооноос томилогдсон шүүгч

---оОо---

ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО